

Эрүүл мэндийг дэмжих сан

Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх тухай

№	Зөвлөмж	Биелэлт
1	<p>Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгөөр бэлтгэсэн материалын орлого зарлагын гүйлгээг бараа материалын дансаар дамжуулан бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар “Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, Сангийн сайдын 2008 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 17-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн аудитын “Тохиолдсон байх”, “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.</p>	<p>Эрүүл мэндийг дэмжих сангийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.</p>
2	<p>Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам”-ын 4.6-д “Сангаас санхүүжилт авахаар шалгарсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулна” гэж заасныг зөрчин хэвлэл мэдээллийн 12 хуулийн этгээдтэй байгуулсан 144.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээнд Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурсан нь санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.</p>	<p>Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам”-ын 4.6-д “Сангаас санхүүжилт авахаар шалгарсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулна” гэсэн заалтыг мөрдлөг болгон ажиллаж байна.</p>
3	<p>Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөл 2017 оны санхүүжилтийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸ дүгээр зүйлийн 21⁸.2-д заасны дагуу ангилж хуваарилаагүй нь хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Хэмжилт”, “Иж бүрэн байх”, “Тохиолдсон байх”, гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</p>	<p>Эрүүл мэндийг дэмжих сангийн удирдах зөвлөл хуралдан Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журмын 2.4-д зааснаар, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸ дугаар зүйлийг үндэслэн ангилж хуваарилан, үйл ажиллагаагаа явуулж байна.</p>
4	<p>Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг шалгахад тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн хөрөнгийн зарцуулалт, хэмнэлт хэтрэлтийн шалтгааны тайлбар, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээний хэсэгт санхүүжилт болон зарцуулалтын гүйлгээ зэрэг мэдээллийг вэб сайтад байршуулаагүй байна. Энэ нь аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>	<p>2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн “Шилэн дансны тухай” хуулийг мөрдөн ажиллаж байна.</p>

Албан шаардлагад хариу хүргүүлэх нь

№	Албан шаардлагын утга	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	<p>Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 180.1 сая төгрөгийн хэвлэлийн цех, мэдээллийн студийн тоног төхөөрөмжийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад 186.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Өмчийн харилцааны газрын зөвшөөрөлгүйгээр тус тус худалдан авч зарцуулсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ”, 3.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гарган хуульд заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулна”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸.2-д “Энэ хуулийн 21⁸.1-д заасан сангийн хөрөнгийг дараах чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна”, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд худалдаж авсан үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар шийдвэрлүүлэн Эрүүл мэндийн яамны хөрөнгөд шилжүүлэн авах, цаашид сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх. 	<p>Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд худалдаж авсан үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А-4/1205 тоот албан бичгийг үндэслэн Хууль тогтоомжийн дагуу Нийгмийн эрүүл мэндийн төв өөрийн хөрөнгөд бүртгэсэн байна.</p>

2	<p>Гадаад томилолтын зардлын төсвийг валютаар олгохдоо арилжааны банкны ханшаар тооцож олгосон, VIP-ийн үйлчилгээ визийн хураамжийн нийт 3.1 сая төгрөгийг Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалын тогтоосон хэмжээнээс илүү олгосон, анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 8 дугаар зүйлийн 8.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай , хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтууд, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” гэсэн тушаалыг тус тус зөрчсөн байна.</p> <ul style="list-style-type: none"> • Сангийн хөрөнгийг хууль журмын дагуу үр ашигтай зарцуулах, дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх. 	<p>Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг мөрдөн Сангийн хөрөнгийг хууль журмын дагуу үр ашигтай зарцуулах, дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллаж байна.</p>
---	---	---